**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 11 өдөр Дугаар А/575

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо “Ариун энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 29 дугаар хороо “Ариун энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн нийт 8,214,049,90 (найман сая хоёр зуун арван дөрвөн мянга дөчин есөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Ариун энэрэл” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Энхтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 10 нэр төрлийн нийт 4,540,739.00 (дөрвөн сая таван зуун дөчин мянга долоон зуун гучин ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, 5 нэр төрлийн 3,673,310.90 (гурван сая зургаан зуун далан гурван мянга гурван зуун арван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгахыг Сонгинохайрхан дүүргийн 29 дугаар хороо “Ариун энэрэл” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Энхтуул)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 11 -ны өдрийн А/535 дугаар тушаалын хавсралт

Байгууллагын нэр: Ариунэнэрэл ӨЭМТ

## Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ | Байгуулсан элэг | Үлдэгдэл өртөг | Эвдрэл гэмтэл | ӨХЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал нэгбүрийн үнэ | НӨАУГ-ын мэргэжилтний үнийн санал | ЭБХХХК-н шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Машин тоног төхөөрөмж** | | | | | | | | | | | | | |
| 1 | Бикс | 23 | ш | 1 | 49,024.00 | 49,024.00 | 49,024.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 2 | Бикс | 13 | ш | 1 | 155,542.00 | 155,542.00 | 155,542.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 3 | Зургийн аппарат | 11 | ш | 1 | 299,900.00 | 299,900.00 | 299,900.00 | - | эвдэрхий | муу | устгах | устгах | устгах |
| 4 | Компьютр ACER | 6 | ш | 1 | 799,000.00 | 799,000.00 | 799,000.00 | - | муудсан | муу | устгах | татах | татах |
| 5 | Боолтны тэргэнцэр | 13 | ш | 1 | 444,773.00 | 444,773.00 | 444,773.00 | - | муудсан | муу | устгах | татах | татах |
| 6 | Тог баригч | 8 | ш | 1 | 400,410.90 | 400,410.90 | 400,410.90 | - | муудсан | муу | устгах | устгах | устгах |
| 7 | Компьютр ACER | 10 | ш | 1 | 900,000.00 | 900,000.00 | 900,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 8 | Шээсний шинжил аппарат | 8 | ш | 1 | 2,200,000.00 | 2,200,000.00 | 2,200,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | устгах | устгах |
| 9 | Агааржуулагч | 8 | ш | 1 | 449,900.00 | 449,900.00 | 449,900.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 10 | Утлагын аппарат | 7 | ш | 1 | 80,000.00 | 80,000.00 | 80,000.00 | - | муудсан | муу | устгах | устгах | устгах |
| | МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ДҮН | | | 10 | **5,778,549.90** | **5,778,549.90** | **5,778,549.90** | - | | | | | |
| **Тавилга, эд хогшил** | | | | | | | | | | | | | |
| 1 | Сургалтын ширээ | 12 | ш | 5 | 104,500.00 | 522,500.00 | 522,500.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 2 | Хурлын сандал | 12 | ш | 15 | 46,200.00 | 693,000.00 | 693,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | устгах | устгах |
| 3 | Саарал шкаф | 11 | ш | 1 | 380,000.00 | 380,000.00 | 380,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 4 | Эмч ширээ | 12 | ш | 2 | 240,000.00 | 480,000.00 | 480,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| 5 | Сувилагч ширээ | 12 | ш | 2 | 180,000.00 | 360,000.00 | 360,000.00 | - | эвдэрхий | муу | устгах | татах | татах |
| | Тавилга, эд хогшлийн дүн | | | 25 | **950,700.00** | **2,435,500.00** | **2,435,500.00** | | | | | | |
| | **Нийт данснаас хасах хөрөнгийн дүн** | | | | | **8,214,049.90** | **8,214,049.90** | | | | | | |
| | Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | | | | | | | | | |
| | Устгах хөрөнгө | | | | | 3,673,310.90 | | | | | | | |
| | Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | 4,540,739.00 | | | | | | | |